911 ОНЫ МОНГОЛЫН ТУСГААР ТОГТНОЛЫН ХӨДӨЛГӨӨНИЙ ШАЛТГААНЫГ СУДЛАХ НЬ
(Товчлол)

ЛАНЬ МЭЙХУА[*]

Тусгаар тогтнолын хөдөлгөөний шалтгаан төвөгтэй бөгөөд үүнийг тэрлэгч би түүнийг анхдагч шалтгаан, шууд шалтгаан, хамгийн эцсийн шалтгаан гэж 3 хуваан үзлээ. Анхдагч шалтгаан нь эдийн засгийн уналт сүйрэл ба Манж Чин улсын түшмэдийн чадваргүй байдал, шууд шалтгаан нь Манжийн засгийн газраас Монголд хандах бодлогын өөрчлөлт хийгээд Сандо,Тан Зайли зэрэг хүмүүсийн засаглал, хамгийн эцсийн шалтгаан нь Манж Чин улсын мөхөл юм. Зохиогч би вээр энэ өгүүлэлдээ Орос Улс энэ хөдөлгөөнд оролцож, үүрэг гүйцэтгэсэн. Мөн Манжийн эсрэг урьд өмнө нь гарч байсан тэмцэл нь энэхүү тусгаар тогтнолын хөдөлгөөн зүгээр нэг хэрэг явдал биш, дургуйцлын бодит үр дүн юм гэдгийг харуулав. Эдгээр шалтгаанд, бүхий л эдийн засгийн уналт, манжийн засгийн газраас монголд хандах бодлогын өөрчлөлт хийгээд Манж гүрний мөхөл зэрэг орчны их хувирал өөрчлөлтийн хүчин зүйл бол тусгаар тогтнолын гол хүчин зүйл, улмаар Оросын оролцоо хийгээд хувь хүний сөрөг үйлдэл нь дагалдах хүчин зүйл болно.

XIX зууны сүүлийн хагаст Монголд Хятадын худалдаачид олон жилийн турш нэвтэрч, монголчуудын өр үстэй толгойноос нь илүү гарч, хүнд хэцүү ажлын дарамтанд байж, эдийн засгийн хувьд сүйрэлд орсон юм. Манжийн засгийн газар эрх үүргээ дээшлүүлсний дараа Монголын ноёдын байр суурь доошилж нүүрэн дээрээ Манж Чин улсын ордны ёсорхлыг хүлээж байсан ч улс төрийн бодит байр суурь нь урьдын адил байж чадаагүй юм. Үүнээс гадна Манжийн засгаас Монголд сууж байсан түшмэдийн чадвар сайнгүй байсан нь монголчуудын итгэл алдрахад хүргэжээ. Иймээс ч монголчууд Манж Чин улсын засгийн газарт сэтгэл цөхөрч, үзэн ядах нь өдрөөс өдөрт гүнзгийрэн дараа дараалан эсэргүүцлийн хөдөлгөөн олон удаа гарсан юм.

Хэдийгээр Манжийн засгийн газар гадны улсын хүчирхийлэлд өртөж, дотоодын эсэргүүцлийн хүчин дайн дэгдээж байсан ч эдгээр эсэргүүцэл тэмцэл нь хязгаарлагдмал, түр зуурын шинжтэй, эв нэгдэлгүй байсны улмаас монголчууд улс төрийн талаар өөр гарц олж чадаагүй юм.

XIX-XX зууны зааг дээр Манж Чин улсын засгийн газрын

[*] Лань Мэйхуа - Тайваний Улс төрийн их сургуулийн дэд профессор, дэд доктор

хямрал улам гүнзгийрч, хөх морин жилийн (1895) дайнд ялагдаж, холбоотон 8 гүрний цэргийн албадлагаар Манжийн засгийн газар, газар нутгаа таслан, төлбөр өгч, улмаар хувьсгалт хүчин өдрөөс өдөрт хүчирхэгжин, Манж Чин улс арга буюу өргөн хүрээтэй шинэчлэлт хийх шаардлагатай болсон юм. Ийм нөхцөлд, Монгол завшааныг ашиглаж, Оросын тусламжийг авч, тусгаар тогтнох гэж бодсон боловч зохистой цаг нь болоогүй байснаас зорилгодоо хүрч чадсангүй. Шинэ засгийн бодлогын шинэтгэлийн явцад, Манж Чин улс Монголд явуулж байсан, монгол хүнийг хамгаалах, Монгол Хятадын харилцааг хаах, хуучин бодлого монгол газар тариалан эрхлэх хятад иргэдийг зах хязгаарт нүүлгэн авчирч хил хязгаарын хамгаалах шинэ бодлогоор өөрчлөхөд хүрсэн юм. Монгол нь Чин Улсын Засгийн газраас Өвөр Монголд явуулж байсан олон арга хэмжээ, түүний ур дагаврыг хараад, сэжиглэн айж, "шинэ засгийн бодлого" гэгчид эрс дургүйцэж, шинээр ирсэн Сандо, Тан Зайли зэрэг хүмүүс шинэ засгийн бодлогыг улам хүчтэй явуулж, шинэ ирсэн монголчуудын түгшүүрийг улам төрүүлж, тусгаар тогтнолын замыг хайхад хүргэсэн юм.

XIX зууны дунд үеэс эхлэн Орос улс Монголын талаархи бодлого идэвхжүүлж, Монголтой харилцаагаа өдөр ирэхүйеэ ойртуулсан юм. Хэдийгээр тухайн үедээ Оросын сонирхол эдийн засгийн эрх ашиг байсан боловч Оросоос Монголд сууж байсан түшмэдүүд Оросын худалдаачдын нөлөөгөөр хэзээ нэг цагт тусгаар тогтнох гэж эрмэлзэхдээ Оросын тусламжийг авах цаг ирнэ. Тиймээс монголчууд тусгаар тогтнолоор шийдвэл тусламж эрэх субъект бол Орос улс болно гэсэн сэтгэгдэлтэй болсон юм. Хэдийгээр Орос улс Монголд шунахайран санаархаж байсан ч тухайн үеийн олон улсын байдал болон Орос,Хятадын харилцаа Манжуурын бүс нутагт улам их ашигтай болно гэдэг үүднээс Оросын засгийн газар Монголын тусгаар тогтнолд дэмжлэг үзүүлээгүй байна. Гагцхүү Орос улс нь Монголын автономийг дэмжиж, энэ удаагийн тусгаар тогтнох хөдөлгөөнд гол дамжуулан зохицуулагч болж тоглосноос бус өдөөн хатгагч болоогүй юм.

Манжийн засгийн газраас Монголын талаархи бодлогоо өөрчилж, Монголд явуулсан шинэ засгийн бодлогын арга хэлбэр нь монголчуудыг тусгаар тогтноход хүргэж, улмаар Манжийн ноёрхол балран унаснаар монголчуудыг тусгаар тогтнол бол цорын ганц сонголт гэж үзэхэд хүргэж, тэд 200 гаруй жилийн өмнөх эвслийн холбоотон болж байсан нь бүр үгүй болсноор тэднийг хуучин тусгаар тогтносон байдлаа зайлшгүй сэргээхэд хүргэв. Монголчуудын үзлээр, манжийн ноёрхол унасан нь тэдэнд тусгаар тогтнох аятай тохиол болсон бөгөөд нөлөөлөх хүч мэдээжийн тодорхой юм.

Хувь хүний сөрөг үйлдэл нь монголын хэсэг ноёд, ван, гүн

нарын үүсгэсэн тусгаар тогтнох хөдөлгөөний нэг шалтгаан гэж хэлж болно. Тухайлбал, монголын эрдэмтэн Л.Жамсран үзэхдээ, Ханддорж нь тусгаар тогтнолын хөдөлгөөнд идэвхитэй түлхэц өгсөн нь түүний хүүг Манжийн засгийн газар хөнөөсөнтэй нэлээд холбоотой юм.

Харин эдийн засгийн бүхий л уналт, Манж Чин улсын Монголд явуулж байсан бодлогын өөрчлөлт хийгээд Манжийн ноёрхол мөхсөн зэрэг холбогдох орчины их хувиралтын голлох хүчин зүйлстэй харьцуулбал, эдгээр хувь хүн ба Орос улсын оролцоо нь дараагийн хүчин зүйл болох юм.

Хятад хэлнээс орчуулсан Л.БЭГЗЖАВ